


Зочид Буудлууд	Одны зэрэглэл	Байгуулагдсан огноо	Өрөөний тоо	Хүчин чадал	Үйлчилгээний төрөл	Хотын төвөөс зай
Баянгол ЗБ	4	1964	215	400	20	3 минут
Улаанбаатар ЗБ	5	1961	219	450	15	хотын төв
Блю Скай ЗБ	5	2012	200	300	5	хотын төв
Кемпински ЗБ	4	2005	102	150	6	12 минут
Рамада ЗБ	4	2012	128	200	9	15 минут
Чингис Хаан ЗБ	4	1995	192	300	14	10 минут

Эх үүсвэр: Стандарт инвестмент ХХК, 2012 он



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Монголд өнөөдрийн байдлаар нийт 326 гаруй том жижиг зочид буудал үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс Улаанбаатар хотод 135 зочид буудал үйл ажиллагаагаа явуулдаг. Монгол Улсыг зорьж буй жуулчдын тоо жил ирэх бүр өсч байгаа ба 2012 оны эхний 9 сарын байдлаар нийт 378,800 жуулчин хилээр орж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.7 хувиар өссөн байна.

Компанийн өсөлт, хөгжил

1961 онд үйл ажиллагаагаа эхлүүлсэн Улаанбаатар ЗБ нь 2006 онд таван одын зэрэглэл авахын тулд 2 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалтаар олон улсын стандартад нийцэхүйц орчин үеийн засвар шинэчлэлийг хийсэн байна. Мөн агааржуулалтын систем суурьлуулахад зориулан 500 гаруй сая төгрөг зарцуулжээ.

Монголын зочид буудлуудын холбооноос 2007 онд Улаанбаатар ЗБ-ыг хамгийн шилдэг зочид буудлаар шалгаруулжээ. Мөн үйл ажиллагааныхаа туршид хамгийн шилдэг байгууллага, анхны 4 одтой, анхны 5 одтой зочид буудал, хамгийн найдвартай байгууллагаар шалгарч, ерөнхийлөгчийн нэрэмжит бүтээлийн шагналыг хүртсэн байна.

Улаанбаатар ЗБ нь 450-500 хүний хүчин чадал бүхий ресторан, 20-100 хүн хүлээн авах хүчин чадал бүхий нийт 4 хүлээн авалтын заалтай ба саун, жакузи, фитнес ба бялдаржуулах төв, амралтын өрөөнүүд, буфет, бизнес төв, бэлэг дурсгалын дэлгүүр, татваргүй барааны дэлгүүр, үсчин, валют солих цэг зэргээр үйлчилдэг байна.

УБ хотоос 80 км зайтай Тэрэлжид 5.3 км² талбайд Улаанбаатар-2 салбар ЗБ 1997 оноос байгуулагдан, 2008 онд 3 одны зэрэглэлтэй болсон ба 37 өрөө, 180 м² бүхий 5 хурлын заал, саун, Заан тэрэлж голфын 9 ба 18 нүх бүхий 2 га зүлгэжүүлсэн талбайтай ажээ. Мөн уулын авиралт, морь унах, нум сум харвалт, теннис, гулгалт, загас агнуурын үйлчилгээг үзүүлдэг байна. Ар хөвч гэр зочид буудал нь 80 зочин хүлээн авах хүчин чадал бүхий 13 гэр

гэр буудал, тансаг зэрэглэл болон стандарт өрөөнүүдтэй болно.

Дүгнэлт

Улаанбаатар ЗБ ХК 2011 онд 5.5 тэрбум төгрөгийн орлого олж, 2.3 тэрбум төгрөгийн зардал гаргасан ба 2.3 сая төгрөгийн ашигтай ажилласан. 2010 онд богино хугацаат өр төлбөр 0.54 сая төгрөг байсан ба 2011 онд 0.106 сая төгрөгөөр өсч 0.65 төгрөг болсон байна. Нэгж хувьцаанд ногдох ашиг 2010 онд 3,746 төгрөг, 2011 онд 6,863 төгрөг байжээ. ULN хувьцааны дундаж үнэ 2010 онд 26,044 төгрөг, 2011 онд 44,061 төгрөг байжээ. Үүнтэй уялдан үнэ ба эзэмшигчдийн өмчийн харьцаа (P/B) нь 2010 онд 1.38, 2011 онд 1.75 байсан ба энэ нь Улаанбаатар ЗБ ба жуулчлалын салбарын ашиг нэмэгдэж буйг харуулж байна. Үнэ ба ашгийн харьцаа (P/E) нь 2010 онд 6.9, 2011 онд 6.42 болж буурсан нь цэвэр ашгийн өсөлт ULN хувьцааны зах зээлийн дундаж үнийн өсөлтөөс харьцангуй их байснаас шалтгаалжээ. Нийт хөрөнгийн өгөөж (ROA) ба эзэмшигчдийн өмчийн өгөөж (ROE) нь 2011 онд 18 ба 25 хувь байгаа нь нийт хөрөнгийг болон эзэмшигчийн өмчийг ашиглан 18 хувь, 25 хувийн ашиг олж байгааг харуулж байгаа болно. Энэ нь 2010 онтой харьцуулахад 2011 онд менежментийн өөрчлөлтийн үр дүн сайнаар нөлөөлснийг харуулж байна. Улаанбаатар ЗБ ХК нь 1993 оноос 2012 оныг хүртэл 78-320 төгрөгийн ногдол ашиг тараасан байна.

Холбоо барих

Хаяг:

Стандарт Инвестмент ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо
Жигжиджавын гудамж 5/3

Шуудангийн хайрцаг:

Төв шуудан, Улаанбаатар 15160,
Хайрцагны дугаар 1487

Утас: +976 7011 4433

Факс: +976 7011 4433

www.standardinvestment.mn

info@standardinvestment.mn

Мэдэгдэл

Энэхүү судалгааг зөвхөн мэдээлэл өгөх зорилгоор бэлдсэн бөгөөд бүх мэдээллийг найдвартай, сайн санааны үүднээс гаргасан гэж үзсэн эх сурвалжаас авч боловсруулсан хэдий ч мэдээлэл тус бүрийг нэг бүрчлэн хянаж шалгаагүй болно. Тиймээс Стандарт Инвестмент ХХК нь эдгээр мэдээллийг үнэн зөв, бодит бөгөөд бүрэн бүтэн байдалд баталгаа гаргахгүй бөгөөд мэдээллийг дамжуулахаас үүссэн аливаа алдааг хариуцахгүй. Түүнчлэн энэхүү мэдээллийг ашигласнаас учирсан аливаа хохиролд Стандарт Инвестмент ХХК ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

Энэхүү мэдээлэл нь ямар нэгэн үнэт цаасны худалдан авах, худалдах санал буюу хөрөнгө оруулалтын зөвлөгөө биш юм. Энд дурдсан үнэ ханшийн мэдээ, бусад тоон мэдээлэл, тайлбар зэрэг нь зөвхөн тухайн мэдээллийг бэлтгэх үеийн байдлыг илтгэх бөгөөд өөрчлөгдөж, хувьсаж болно. /Стандарт Инвестмент ХХК өөрчлөлтийг мэдэгдэх албагүй/. Мэдээллийг зөвхөн хаягласан хувь хүн болон албан байгууллагын хэрэглээнд зориулсан ба Стандарт Инвестмент ХХК-ийн зөвшөөрөлгүйгээр мэдээллийг ямар нэгэн хэлбэрээр цааш нь дамжуулах, түгээх, хуулбарлахыг хариглоно.

© 2012 Standard Investment LLC

